

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2014 оны 06 дугаар
сарын 02 ны өдөр

Дугаар 138 /А-208

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Усан замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ыг 1 дүгээр, усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээний загварыг 2 дугаар, усан замын тээврийн хэрэгслийн хувийн хэргийн загварыг 3 дугаар, усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаар, түүнийг тэмдэглэх байршил, хэмжээг 4 дүгээр, усан замын тээврийн хэрэгсэлд техникийн үзлэг хийсэн тухай актын загварыг 5 дугаар, усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын хуудасны загварыг 6 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн яамны Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газар /Б.Жаргал/-т, Байгаль орчин ногоон хөгжлийн яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.Энхбат/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2006 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 26/58 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД
 ТЕХНИКИЙН БОЛОН ЭКОЛОГИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙХ,
 ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, УЛСЫН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь усан замын тээврийн үйл ажиллагааг гол, мөрөн, нуурын экологи, байгаль орчинд сөрөг нөлөөгүй эрхлэхэд төрийн хяналт, зохицуулалтыг чиглүүлэн, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийж хөвөлтийн аюулгүй байдлыг ханган, усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох, шилжилт хөдөлгөөн хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас эрх олгогдсон усан замын тээврийн хяналтын улсын байцаагч энэхүү журмыг баримтлан хийнэ.

1.3. Усан замын тээврийн хэрэгсэлд экологийн хяналтын үзлэгийг тухайн орон нутаг дахь байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль орчны хууль тогтоомжид нийцүүлэн Байгаль орчин, ногоон хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан экологийн хяналтын үзлэг хийхэд баримтлах шаардлагын дагуу хийнэ.

1.4. Байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүссэн, усан замын тээврийн хэрэгслийн осол, зөрчил гарсан болон бусад шаардлагатай тохиолдолд усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулж болно. Ажлын хэсгийг усан замын тээврийн хяналтын улсын байцаагч ахлаж, тухайн орон нутаг дахь холбогдох мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагын төлөөллийг оруулна.

1.5. Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон улсын дугаар олгох, шилжилт хөдөлгөөн хийх, бүртгэлээс хасах, үйл ажиллагааг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн явуулах бөгөөд усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан байгуулж лавлагаа гаргана.

1.6. Энэхүү журмын биелэлт, хэрэгжилтэд мэргэжлийн холбогдох байгууллагын хяналтын улсын байцаагчид хяналт тавина.

2. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх

2.1. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийлгүүлэхэд дараах баримт бичиг бүрдүүлнэ.

Үүнд:

2.1.1. Иргэн бол иргэний үнэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээ;



2.1.2. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн паспорт, усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ, бусад дагалдах баримт бичиг;

2.1.3. Усан замын тээврийн хэрэгсэлд их засвар хийсэн бол түүнийг нотолсон баримт бичиг;

2.1.4. Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч солигдсон буюу бусад тохиолдолд хийгдсэн шилжилтийн тухай баримт бичиг;

2.1.5. Улсын тэмдэгтийн хураамж болон бусад холбогдох албан татварыг төлсөн баримт.

2.2. Ашиглагдаж байгаад импортоор орж ирсэн усан замын тээврийн хэрэгслийг техникийн болон экологийн хяналтын үзлэгт хамруулна.

3. Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгох

3.1. Усан замын тээврийн хэрэгслийг 16 буюу түүнээс дээш насанд хүрсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаягаар бүртгэж, орон нутгийн харъяаллын дагуу ялгах тэмдэг бүхий улсын дугаар, гэрчилгээ олгоно.

3.2. Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ, бүртгэлийн картыг нууцлалын шаардлагыг хангаж хэвлүүлэн, бүртгэж хадгална. Гэрчилгээг, энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээний загварын дагуу олгоно.

3.3. Бага оврын усан онгоц, завь, катер нь хувийн хэрэгтэй байх ба хувийн хэргийг журмын 3 дугаар хавсралтаар баталсан бага оврын усан онгоц, завь, катерын хувийн хэргийн загварын дагуу холбогдох байгууллагаас олгоно.

3.4. Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичиг бүрдүүлнэ.

Үүнд:

3.4.1. Иргэн бол иргэний үнэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээ, хүсэлт;

3.4.2. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн паспорт, бусад дагалдах баримт бичиг;

3.4.3. Импортоор оруулж ирсэн бол гаалийн бүрдүүлэлт хийснийг нотлох баримт бичиг;

3.4.4. Усан замын тээврийн хэрэгслийг Монгол Улсад үйлдвэрлэж, угсарсан бол түүнийг нотолсон баримт бичиг;

3.4.5. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн акт, дүгнэлт;

3.4.6. Улсын тэмдэгтийн хураамж болон бусад холбогдох албан татварыг төлсөн баримт.


4. Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх

4.1 Дараах тохиолдолд усан замын тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хийнэ.

Үүнд:

4.1.1. Өмчлөгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь усан замын тээврийн хэрэгслээ бусдад худалдах, бэлэглэх, солилцох.

4.1.2. Өмчлөгч иргэний оршин суугаа хаяг, аж ахуйн нэгж, байгууллагын байршил өөрчлөгдөх.



4.1.3. Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүр өөрчлөгдөх;

4.1.4. Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч нас барсан тохиолдолд өв залгамжлагчийн, мөн шүүхийн шийдвэрээр усан замын тээврийн хэрэгслийг хураасан буюу шилжүүлсэн бол шийдвэрт заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр дээр тус тус бүртгэнэ.

4.1.5. Татан буугдаж бүртгэлээс хасагдсан аж ахуйн нэгж, байгууллагын усан замын тээврийн хэрэгслийг харъяалах нутаг дэвсгэрийн татварын албаны тодорхойлолтыг үндэслэн бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр дээр шилжүүлэн бүртгэж болно.

4.2. Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийхэд дараах баримт бичгийг үндэслэнэ.

Үүнд:

4.2.1. Аж ахуйн нэгж, байгууллагаас, өөр аж ахуйн нэгж, байгууллагад усан замын тээврийн хэрэгслийг шилжүүлбэл шилжүүлэн өгч байгаа аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирлын шийдвэр, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, холбогдох татвар хураамж төлсөн баримт болон шилжүүлэн авч байгаа аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирлын шийдвэр, албан бичиг, гэрчилгээ;

4.2.2. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн өмчлөлийн усан замын тээврийн хэрэгслийг иргэдэд шилжүүлбэл тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирлын шийдвэр, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, холбогдох татвар хураамж төлсөн баримт шилжүүлэн авч байгаа иргэний үнэмлэх, өргөдөл;

4.2.3. Иргэн өөрийн өмчлөлийн усан замын тээврийн хэрэгслийг аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлбэл тухайн иргэний өргөдөл, иргэний үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, холбогдох татвар хураамж төлсөн баримт, шилжүүлэн авч байгаа аж ахуйн нэгж, байгууллагын албан бичиг, гэрчилгээ;

4.2.4. Иргэд хоорондоо усан замын тээврийн хэрэгслээ шилжүүлбэл иргэн тус бүрийн иргэний үнэмлэх, шилжүүлэх өргөдөл, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, холбогдох татвар хураамж төлсөн баримт.

5. Усан замын тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах, гэрчилгээг нөхөн олгох


5.1. Усан замын тээврийн хэрэгслийг техникийн хувьд цаашид ашиглах боломжгүй болсон буюу усанд живсэн тохиолдолд өмчлөгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс нэг сарын дотор хасуулна.

5.2. Усан замын тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасуулахын тулд дараах баримт бичгийг бүрдүүлж усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

Үүнд:

5.2.1. Данснаас хассан тухай аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирлын шийдвэр, усан замын тээврийн хэрэгслээ бүртгэлээс хасуулах тухай өмчлөгчийн өргөдөл;

5.2.2. Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ;



5.3. Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөж авахын тулд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

Үүнд:

5.3.1. үрэгдүүлсэн гэрчилгээг нөхөж авахыг хүссэн өргөдөл, албан бичиг;

5.3.2. үрэгдүүлсэн гэрчилгээг өдөр тутмын сонинд зарлуулж хүчингүй болгосон тухай баримт;

5.3.3. гэрчилгээний үнэ тушаасан баримт;

5.4. Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгосон тохиолдолд гэрчилгээн дээр "нөхөв" тэмдэглэл хийнэ.

5.5. Хэрэглэх явцад хуучирч муудсан бичлэг тэмдэглэл нь баларсан гэрчилгээг өмчлөгчийн хүсэлтээр үнийг төлүүлэн сольж болно.

6. Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

6.1. Усан замын тээврийн хэрэгслийг өмчилж авснаас хойш 14 хоногийн дотор усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж шинээр гэрчилгээ, улсын дугаар авах буюу шилжилт хөдөлгөөн хийлгүүлнэ.

6.2. Усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаарыг энэхүү журмын 4 дүгээр хавсралтаар баталсан загварын дагуу байршуулж тэмдэглэнэ.

6.3. Усан замын тээврийн хэрэгслийг техникийн хувьд бүрэн бүтэн ашиглах ба түүний техникийн байдалд тогтмол үзлэг хийж, илэрсэн эвдрэл гэмтлийг засах, өнгө үзэмжийг сайжруулах, усан замын тээврийн хэрэгслийн хувийн хэргийг бүрэн хөтөлнө.

6.4. Усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн тавьсан шаардлагыг бүрэн хангаж, усан замын тээврийн хэрэгслээ техникийн болон экологийн хяналтын үзлэгт товлогдсон хугацаанд бүрэн хамруулна.


6.5. Усан замын тээврийн хэрэгслийг шинээр хөдөлгөөнд оролцуулах, хөдөлгүүрийг солих буюу их засвар хийсэн тохиолдолд тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэн зохих бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг хийлгэнэ.

6.6. Усан замын тээврийн хэрэгслийн зориулалт өөрчлөхийг хориглоно.

7. Улсын байцаагчийн эрх, үүрэг:

7.1. Усан замын тээврийн хяналтын улсын байцаагч нь энэхүү журмын 5 дугаар хавсралтаар баталсан "Бага оворын усан онгоц, завь, катерт техникийн (анхан шатны) үзлэг хийсэн тухай акт" ба 6 дугаар хавсралтаар баталсан "Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын хуудас" -ыг баримтлан усан замын тээврийн хэрэгслийн үзлэг, хяналтын үйл ажиллагаагаа явуулна.

7.2. Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь Байгаль орчин, ногоон хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан усан замын тээврийн хэрэгсэлд экологийн хяналтын үзлэг хийх шаардлагыг баримтлан, усан замын тээврийн хэрэгслийн шатахууны савны битүүмжлэл



болон хатуу хог хаягдал, ахуйн бохир ус /00, хоолны газрын үйлчилгээнээс гарсан шингэн хаягдал/-ыг агуулах савны битүүмжлэл, багтаамж, хүрэлцээг хангаж буй эсэхэд хяналт хийж дүгнэлт гаргана.

7.3. Үзлэгт хамрагдсан усан замын тээврийн хэрэгсэл нь техникийн болон экологийн хяналтын шаардлагыг хангаагүй тохиолдолд өмчлөгчид доголдол, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүргийг өгч тухайн орон нутгийн усан замын тээврийн хяналтын улсын байцаагчид шалгуулан дахин үзлэг хийлгэх арга хэмжээг авах талаар шаардлага тавина.

7.4. Үзлэгээр илэрсэн доголдол, дутагдлыг арилгаагүй болон үзлэгт оруулаагүй усан замын тээврийн хэрэгслийн талаар холбогдох байгууллагуудад мэдэгдэж, усан замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглох буюу шаардлагатай гэж үзвэл түр саатуулах, мөн хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах эрхтэй.

7.5. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийсэн акт буюу дүгнэлтийг 14 хоногийн дотор тухайн орон нутгийн захиргаанд бичгээр хүргүүлнэ.

7.6. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийхдээ нийтээр дагаж мөрдөх хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, норм, норматив, стандартыг мөрдөж ажиллах бөгөөд тэдгээр хууль тогтоомжид заасан улсын байцаагчийн бүрэн эрхийн дагуу хяналтыг хэрэгжүүлнэ.

8. Бүртгэгч байгууллагын эрх, үүрэг:

8.1. Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, гэрчилгээ олгох, шилжилт хөдөлгөөн хийх, бүртгэлээс хасах үйл ажиллагааны үнэн зөв байдлыг хариуцна.

8.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас усан замын тээврийн хэрэгслийг бүртгүүлэх, улсын дугаар болон гэрчилгээ авах, шилжилт хөдөлгөөн хийлгүүлэх, бүртгэлээс хасуулах хүсэлт гаргасан бол 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

8.3. Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн хийлгүүлэх, бүртгэлээс хасуулахтай холбогдсон зөрчил гарсан тохиолдолд түүнийг арилгуулах талаар арга хэмжээ авах эрхтэй.

8.4. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх хугацаа болон хамрагдах нутаг дэвсгэр, байрлалыг олон нийтэд урьдчилан өдөр тутмын буюу бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр 14-өөс доошгүй хоногийн өмнө мэдээлнэ.


8.5. Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг тухайн орон нутагт хэрэгжүүлж буй байгууллагад усан замын тээврийн хэрэгслүүдийг техникийн болон экологийн хяналтын үзлэгт бүрэн хамруулах бэлтгэл арга хэмжээг авахуулах тухай мэдэгдэнэ.

— 0 —



Зам, тээврийн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын хамтарсан 20... оны 38/ дугаар тушаалыг 21/ А 208 дугаар хавсраг

Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээний нүүр тал
(арын дэвсгэр өнгө хөх цэнхэр байх ба соёмбо байрдуулна)



Техник, экологийн хяналтын үзлэг хийсэн тэмдэглэл

Он сар өдөр	Техник-ийн байдал	Үзлэгийн дүгнэлт	Байцаагчийн гарын үсэг (тэмдэг)

Засвартай бол хүчлэгүй

Хүчинтэй хугацаа:

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр хүртэл хүчинтэй.

/тэмдэг/ _____ /гарын үсэг/

Улсын бүртгэлээс хассан тухай тэмдэглэл:

20... оны ... дугаар сарын ... -ны өдрөөс улсын бүртгэлээс хасав.

/тэмдэг/ _____ /гарын үсэг/

Гэрчилгээний дотор тал

Өмчлөгч (эзэмшигч) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг

(тэмдэг) _____ 20... он ... сар ... өдөр

Өөрчлөгдсөн тэмдэглэл

(тэмдэг) _____ 20... он ... сар ... өдөр

Өөрчлөгдсөн тэмдэглэл

(тэмдэг) _____ 20... он ... сар ... өдөр



УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

(MGL)

Дугаар №

Монгол Улсын Зам, тээврийн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын хамтарсан 20... оныг ... дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар тушаалыг үндэслэн ... аймаг (хот)-ийн ... сум (дүүрэг)-ын харъяалалтай усан замын тээврийн хэрэгсэлд гэрчилгээ олгов.

Усан замын тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолт
Улсын дугаар _____
Нэр _____
Марк _____
Ангилал _____
Зориулалт _____
Үйлдвэрлэсэн огноо _____
Хөдөлгүүр, багтаамж _____
Даац _____
Зорчигчдын багтаамж _____
Монгол Улсад оруулж ирсэн огноо _____

Гэрчилгээ өнгөсөн 15/
МОНГОЛ УЛСЫН
МОНГОЛ УЛСЫН
20... оны ... сарын ... өдөр
14-06-09

Зүүн гар тал

Бага оврын усан онгоц, завь, катерын
хувийн хэргийн загвар

№ 000000

Хувийн хэрэг нь бага оврын усан онгоц, завь катерыг
өмчлөх /зээмшигч/ эрх, Монгол Улсын Төрийн далбаа
мандуулан хөвөх эрхийг баталгаажуулж буй баримт бичиг юм.

Улсын дугаар
Өмчлөгч /зээмшигч/-ийн овог нэр

Хаяг:

Байнгын зогсоол

Олгосон:

/гэмдэг/ /гарын үсэг/

20... оны ... сарын ... өдөр

Улсын дугаар

Өмчлөгч /зээмшигч/-ийн овог нэр


Хаяг:

Байнгын зогсоол

Олгосон:

/гэмдэг/ /гарын үсэг/

20... оны ... сарын ... өдөр



Улсын дугаар
Өмчлөгч /зээмшигч/-ийн овог нэр

Хаяг:

Байнгын зогсоол

Олгосон:

/гэмдэг/ /гарын үсэг/

20... оны ... сарын ... өдөр

Их бие

Төрөл, загвар

Үйлдвэрлэгчийн дугаар

Үйлдвэрлэсэн өгнөө, улс

Материал

Агаарт (хөндий) хайрцаг (хөвөгч блок)-тай эзэмшүүр (м?) УЛСЫН...

Ангилалын томъёо



Урт м, өргөн м,
 Хажуу хавирганы өндөр м,
 Хажуу хавирганы уснаас дээшхи хамгийн дээд өндөр м,
 Багтаамж тонн
 Зорчигчийн тоо хүн
 Даац
 Далбааны талбай м²
 Хөвөх бүс, нөхцөл

Хөдөлгүүр			
Төрөл			
Хүчин чадал			
Үйлдвэрийн дугаар			
Улсын байцаагч /гарын үсэг, тэмдэг/			

Бага оврын усан онгоц, завь, катерт заавал байх тоног
 төхөөрөмж, хэрэгслүүд

1. Дохио өгөх хэрэгслүүд
2. Аврах хэрэгслүүд
-
5. Хатаах, гал унтраах хэрэгслүүд
-
6. Зангуу, уяа оосорууд
7. Хангалтын бусад хэрэгслүүд
-

Хөдөлгүүр			
Төрөл			
Хүчин чадал			
Үйлдвэрийн дугаар			
Улсын байцаагч /гарын үсэг, тэмдэг/			

Хөдөлгүүр			
Төрөл			
Хүчин чадал			
Үйлдвэрийн дугаар			
Улсын байцаагч /гарын үсэг, тэмдэг/			

3. Холбооны хэрэгслүүд

.....

.....

4. Навигацын хэрэгслүүд


.....

.....

Техникийн хяналтын үзлэгт хамрагдаж хөвөлтөд тохирсон
 эсэх, тэмдэглэгээ

Огноо	Техникийн байдал	Улсын байцаагчийн гарын үсэг, тэмдэг

Бүртгэлийн дугаар ... 151
 БОЛГОЛ УЛСЫН
 З/Б, ТЭХНИКИЙН ТАМ
 ХҮҮНГАЛ ҮНЭН
 12 уулбар өлгөсөн үзлэгийн гарын үсэг
 20 14 оны 06 сарын 09 нөхцөл



1. Усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаар нь харъяалагдах улс, тухайн орон нутгийг заасан гурван үсэг, усан замын тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн дарааллаар нь олгосон цифрээс бүрдэнэ. Цифр нь 01-ээс эхлэх ба цаашид бүртгэгдсэн усан замын тээврийн хэрэгслийн тооноос хамаарч аравт, зуут, мянгатын оронд шилжих маягаар дугаарлагдана. Жишээ нь: М 01ХӨ - гэсэн улсын дугаарын М үсэг нь Монгол Улс, 01- хамгийн эхэнд бүртгүүлсэн усан замын тээврийн хэрэгслийн дугаар, ХӨ- Хөвсгөл аймаг.

Өмчлөгч /зээмшигч/ нь улсын дугаарын зэрэгцээ усан замын тээврийн хэрэгсэлдээ нэр авах хүсэлт гаргасан бол, түүний санал болгосон нэрийг олгоно.



2. Усан замын тээврийн хэрэгсэлд олгосон улсын дугаарыг тухайн тээврийн хэрэгслийн хамрын хоёр хажуу талд, түүний хошуун талаас, их биеийн уртын 1/4-тэй тэнцэх хэмжээний зайд, их биеийн дэвсгэр өнгөнөөс тод ялгарах өнгийн будгаар буюу зориулалтын наалт нааж тэмдэглэнэ.

Улсын дугаарын үсэг, тооны өндөр 150 мм-ээс багагүй, өргөн нь 100 мм, зураасны өргөн 15-20 мм байх ба дармал том үсгээр бичнэ. Үсгүүд нь тоонуудаасаа тухайн үсгийн буюу тооны өргөнтэй тэнцүү хэмжээгээр тусгаарлагдсан байна. Жишээ нь: **М 01 ХӨ**

Усан замын тээврийн хэрэгслийн зохион бүтээгдсэн онцлогоос хамаарч дээр дурдсан шаардлагыг биелүүлэх боломжгүй тохиолдолд улсын дугаарын хэмжээ 7.6 см-ээс багагүй өндөртэй байх ба дугаар тэмдэглэх байршлыг усан замын тээврийн хяналтын улсын байцаагчаас зөвлөгөө авч тодорхойлно.

**МОНГОЛЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон лицензийн гарын үсэг
2014 оны 06 сарын 09 Нийслэл

Бага оворын усан онгоц, завь, катерт техникийн (анхан шатны) үзлэг хийсэн тухай акт

Энэхүү актыг 20... оны ... сарын ... ны өдөр

(акт үйлдсэн албан тушаалтны овог нэр, албан тушаал)

үйлдэв.

Өмчлөгч (эзэмшигч)

(овог нэр, хуулийн этгээд, байгууллагын нэр)

Хаяг, утас:

Техникийн үзлэгт төрлийн

загвар /модель/-ын бага оворын усан онгоц, завь, катерыг оруулав:

Үйлдвэрлэсэн он....., Үйлдвэрлэсэн улс, Үйлдвэрээс олгосон дугаар....., Их биеийн материал, Уртм, Өргөн м, Хажуу хавирганы өндөрм, Хажуу хавирганы уснаас дээшхи хамгийн дээд өндөр м, Даацт, Зорчигчдын багтаамж хүн, Дарвуулын талбай м², Зохион бүтээсэн арга, Хөдөлгүүрийн төрөл, марк, Тоо, Хүчин чадал, Үйлдвэрээс олгосон дугаар

Техникийн үзлэгээр дараахь үзүүлэлтүүдийг тогтоов:

1. Бага оворын усан онгоц, завь, катерын үндсэн хэмжээсүүд

(баримт бичигт заасан хэмжээтэй нийцэж буйг тогтоох)

2. Багтаамжт, 3. Суулт м.

4. Их биеийн байдал(ерөнхий байдлыг үнэлэх)

5. Жолоодлогын тоног төхөөрөмж

(бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)

6. Зангуу буулгах, татах тоног төхөөрөмж, уяа оосор

(бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)

7. Аврах хэрэгслүүд

(нэр төрөл, тоо ширхэг, бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)

8. Дохионы хэрэгслүүд

(нэр төрөл, тоо ширхэг, бүрэн бүтэн байдлыг үнэлэх)

Зам, тээврийн сайд, Байгаль, орчин, ногоо хөгжлийн сайдын хамтарсан 20... оны 12/11 дугаар тушаалын дугаар хэсэглэл

9. Хангалтын эд зүйлсийн иж бүрдэл
(тоо ширхэг, шаардлагад нийцэж буйг тогтоох)
10. Даац, зорчигчийн багтаамж (хүн)
11. Хөвөх чанар, төхөөрөмж байдал, үл живэх чанар
(ерөнхий байдлыг үнэлэх)
12. Хөвөх чанарын нөөц
13. Хажуу хавирганы уснаас дээшхи хамгийн бага өндөр м,
14. Галын аюулаас урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж, хэрэгслүүд
(бүрэн бүтэн байдал, тоо ширхэг, хэрэглэх хугацаа)
15. Механик тоног төхөөрөмж, хэрэгслүүд
(ерөнхий байдлыг үнэлэх)
16. Хүчин чадлын дээд хязгаар
(техникийн баримт бичгээр тогтоосон)
17. Дарвуул, уяа оосорын байдал
(чанар, шаардлага хангаж буй эсэх)
18. Цахилгааны тоног төхөөрөмж, хэрэгслүүд
(бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)
19. Холбоо, радиохолбооны хэрэгслүүд байгаа эсэх
(төрөл, марж, ажиллагааны бүрэн бүтэн байдал)
- Бага оворын усан онгоц, завь, катерт өгөх ерөнхий дүгнэлт
- (тэнцэнэ, хязгаарлалттай тэнцэнэ, тэнцэхгүй)
- Аялах бүс, нөхцөл:
- Давалгааны өндрийн дээд хязгаар м,
- Эргээс холдох алслалт м,
- Хөдөлгүүрийн хүчин чадлын дээд хязгаар м/хүч
- Даацын дээд хязгаар т

Ангилалын томъёо

(овог нэр, албан тушаал)

Өмчлөгч (эзэмшигч)

(овог нэр, албан тушаал)



Зам, тээврийн сайд, Байгаль, орчин носоон хөгжлийн сайдын хамтарсан 2019 оны 138/А дугаар тушаал дугаар хэвсрэлт

Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын хуудас-1
УХА0444

10 дугаар тушаал
10 дугаар тушаал
10 дугаар тушаал

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Хяналт шалгалт хийх эд анги	Тийм	Үгүй	Улсын байцаагч-ийн дүгнэлт
Дотоод шаталтын хөдөлгүүр					
1	"Усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм"-ийн 4.69	Үндсэн ба туслах хөдөлгүүрийн ажиллагаа найдвартай хөтөлгүүрт тосолгоо хийгдсэн, хөргөлтийн болон түлшний системүүдийн ажиллагаа хэвийн, хөдөлгүүрийн хүчийг цилиндр бүрт жигд тохируулсан, хөдөлгүүрийн эргэлт тогтоосон хэмжээнд			
2	4.72	Бүх даралтат савыг тогтоосон хугацаанд шалгадаг			
Усан замын тээврийн хэрэгслийн машин механизм					
Залуурт тавих шаардлага					
3	4.35	<p>Залуурын тоноглолд аялалын ямар ч нөхцөлд тээврийн хэрэгслийг найдвартай залах үндсэн нөхцөл болох дараахь шаардлага хангагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ○ 0-45 градус хуртгал залуурын буцаж эргэх хугацаа механикжсан залуурын хувьд 30 секунд, гар ажиллагаатай залуурын хувьд 2 минутаас ихгүй байгаа ○ Үндсэн залуураас нөөц залуурын ажиллагаанд шилжих хугацаа нэг минутаас хэтрэхгүй байгаа ○ Жолоодлогын палуб /тавцан/, онгоцны тавцантай үрэлдэхээргүй зайтай, арааны элэгдэл нь хэвийн ажиллагаанд нөлөөлөхөөргүй байгаа ○ Тросс болон залуурын голын элэгдэл тогтоосон хэм хэмжээнээс хэтрээгүй ○ Залуурын тросс чангалагдсан ○ Залуурын машины цахилгаан контактууд цэвэр найдвартай ажиллагаатай 			
Зангуунд тавих шаардлага					
4	4.39	<ul style="list-style-type: none"> ○ Зангуу хураагч нь 2 зангууг нэгэн зэрэг тогтоосон хугацаанд татаж авах хүчин чадалтай ○ зангууны гинжийг хайрцагт хураан төгсгөлийг онгоцны их биед найдвартай бэхэлсэн ○ гинжийн металлийн диаметр 20%-иас хэтрээгүй ○ зангуу хураагч болон шпиллийн тоормоз, гинжийн түгжээ найдвартай 			
Татлага осор					
5	4.41	Татлагын шон, гоцроо, бэхлэгээ найдвартай татлага, осорт гэмтэл учруулж болохуйц хурц			

Байгалийн дугаар 151

МАР ИРИНГЭД

МАР ИРИНГЭД

МАР ИРИНГЭД

20 14 оны 06 сарын 09-ний өдөр

		ирмэг, огцом нугалаа үүсээгүй		
Чирэгч холбоос				
6	4.44	Чирэгчийн гак, арк найдвартай бэхлэгдсэн, түгжээ нь чирэгчийг яаралтай салгах төв удирдлагаар хангагдсан		
7		Чирэгчийн троссны 8 диаметрийн урт тутам элэгдэл 10 хувиас илүүгүй.		
Мачта/Цамхаг/				
8	4.48	Тээврийн хэрэгслийн цамхагийн өдөр, шөнийн дохио, радио антена, буулгах, босгох механизм бүрэн ажиллагаатай		
9	4.49	Гадна харилцааны өдөр, шөнийн дохионууд /яндан, дохио (сирен), дэнлүү, дохио өгөх туг, хонх/ цаг агаарын ямар ч нөхцөлд сонсогдохуйц, үзэгдэхүйц байхаар тоноглогдсон		
Механизм				
10	4.60	Жолоодлогын байрны болон машин ангийн хяналт, хэмжүүрийн самбарын хэрэгсэл бүрэн бүтэн ажиллагаатай		
11	4.61	Тээврийн хэрэгсэлд усны, уурын, түлш, тос, агаар дамжуулалтын хоолой болон цахилгаан шугамын схемүүд байгаа		
12	4.62	Тээврийн хэрэгсэлд байрлуулсан хэмжүүрийн бүх хэрэгслийг жин хэмжүүрийн эрх бүхий байгууллагаас баталгаажуулан лацадсан, ашиглалтын үед тогтоосон хугацаанд хяналт шалгалт хийдэг		
13	4.63	Тогооны болон бусад даралтат савны хамгаалах хавхлагыг эрх бүхий этгээдээр лацдуулсан		
14	4.65	Тээврийн хэрэгслийн механик ашиглалтын зөвөрт дурдсан хугацаанд машин механизм бүрийн эд ангийн элэгдлийг тооцоолж дүнг журналд тэмдэглэдэг		
15	4.66	Жолоодлогын байр ба машин, тогооны ангид байрлуулсан хэмжүүрийн тоног төхөөрөмжийг гэрэлтүүлэх аваарын хэрэгслээр тоноглогсон		
16	4.67	Механизм, систем бүрийн нээлхийг зориулалтын тэмдгээр харуулан дотор нь агуулагдах ус, уурын хөдөлгөөний чигийг сумаар заасан		
17	4.68	Тээврийн хэрэгсэл бүрийн машины эд ангид тусгай маягтын дагуу батлагдсан машины журналтай ба хөтлөлтийг ерөнхий механик хариуцан хийдэг		
Хийн шахуургын төхөөрөмж				
18	4.73	Шахагдсан хийн баллоны тоо ширхэг, багтаамж нь үндсэн, туслах хөдөлгүүрийг асаах, эргэлт шилжүүлэхэд хүрэлцэхүйц тоо хэмжээтэй, баллонд ан цав гараагүй, хий алдаагүй, даралт буураагүй, хамгаалах хавхлаг ба манометр гэмтэлгүй, тослог уур, чийг гаргах илүү хоолой байрлуулсан		
19	4.74	Баллоныг цэнэглэх бүр цэвэрлэдэг		
20	4.75	Хийн шахуургын үндсэн эд ангиудад гажилт, цууралт, цав үүсээгүй, агаарын хоолойнуудаас хий алдаагүй, тосны ба хөргөлтийн системд гэмтэл гараагүй, хамгаалах хавхлагад тохиргоо хийгдсэн гэмтэлгүй, хөдлөх эд ангиудад цохио,		

151

**МОНГОЛЫН
ТЭВЭРИЙН
ТӨХӨӨРӨМЖИЙН
ТӨВӨР**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
19/06/2019 оны 06 сарын 19-ний өдөр

		чимээ үүсээгүй			
Усан замын тээврийн хэрэгслийн цахилгааны тоног төхөөрөмжүүд					
21	4.76	Цахилгаан үүсгүүрүүд хэвийн ажиллагаатай, дохионы гэрэл, гэрэлтүүлэг болон сэнсний далбаа ажиллагаатай			
22	4.77	Усан онгоцны бүх цахилгаан тоноглол техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангасан			
23	4.78	Тээврийн хэрэгслийн цахилгаан тоноглолын ажиллагаа нь радио дамжуулалт буюу радар, луужингийн хэвийн ажиллагаанд нөлөөлөхгүй ажиллагаатай, цахилгаан гаралт тасалдах, оч үсрэх, хэт халах гэх мэт аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авагдсан			
24	4.84	Цахилгаан самбарын өрөөнд дараах багаж хэрэгсэл эд ангиуд байгаа			
		○ Нөөц гал хамгаалагч, дохионы буюу хяналтын гэрэл			
		○ Засварын багаж			
		○ Резин бээлий ба дэвсгэр, нүдний шил, хамгаалах бүрхүүлтэй багаж			
		○ Эмийн сан			
		○ Гал унтраагуур			
25	4.85	○ Гэр чийдэн, шаардлагатай багаж, түлхүүрүүд			
		Кабель утасны гадаргуунууд халаагүй, асаах ба тохируулах аппарат хэрэгсэл ажиллагаатай, машиныг гэмтээж болох үрэлт цохио үүсээгүй, зангууны ороомогт богино холбоо үүсээгүй			
		Хамгаалах хэрэгслийн хүчинтэй хугацаа алдагдаагүй			
		25 Вт-аас дээш хүчдэлтэй бүх цахилгаан тоноглолын төмөрлөг хэсгийг заавал газардуулсан			
		Тээврийн хэрэгслийн их биеийн хоёр хажууд усанд суух өндөр болон усны түвшингээс дээш байрлах хэмжүүрийн заалт тэмдгийг /ачаалах тэмдэг/ бүртгэлийн дүрэмд заасны дагуу зохих өнгийн будгаар будаж байрлуулсан			
		Зогсоолын тоноглолууд			
29	"Усан замын зогсоол байгуулах, түүнийг ашиглах журам"-ын 8	Зогсоолын усны гүний хэмжээг тогтоосон			
30	9	Зогсоол руу орох, гарах замыг зохистой зайд байрлуулсан хөвүүр торхнууд дээр сайтар бэхлэгдсэн тэмдгээр хашиж өдөр, шөнийн аль ч нөхцөлд тод гэрэлтэж байхаар тоногдсон			
31	10	Хөвдөг зогсоолыг зорчигчийн суух, буухад зориулсан бариултай шатаар тоногдсон байх ба зогсоолыг эрэгт хоёр талаас нь найдвартай бэхэлж тогтоосон			



Усан замын тээврийн хэрэгслийн техникийн
хяналтын хуудас-2

✓ -нь бага оворын усан замын тээврийн хэрэгслүүдэд заавал байх шаардлагатай
тоног төхөөрөмж, хэрэгслийг заана

Шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслүүд	Усан замын хувийн тээврийн хэрэгслүүд /усны мотоцикл, цана, чарга/	5 м хүртэл урттай завь, хэрэгслүүд	5м-ээс урт 8 м-ийн завь, хэрэгслүүд
Усан онгоц, завь, хэрэгслийг аюулгүй жолоодох боловсрол олсныг гэрчлэх гэрчилгээ тавцан дээр байгаа эсэх	✓	✓	✓
Усан онгоц, завь, хэрэгслийг аюулгүй жолоодох боловсрол олсныг гэрчлэх гэрчилгээ. /Хэрэв насанд хүрсэн хүний хяналтад биш бол 12-15 настай жолоодогчдоос мөн шаардана/			
Улсын дугаарын гэрчилгээ /усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ	✓	✓	✓
Хувийн хамгаалалтын хөвөгч хэрэгслүүд: I, II, ба III загвар (хүн нэг бүрт)	✓	✓	✓
Усны мотоцикл, бусад хөвөгч хэрэгслээр аялж буй хүн нэг бүр хувийн хамгаалалтын хөвөгч хэрэгсэл (аврах хантааз) -ийг аялалын туршид өмсөх үүрэгтэй. Бага насны 10 ба түүнээс доош насны хүүхдүүд усан замд аялж буй 8 хүртэл м-ийн урттай аливаа усан онгоц, завь, хэрэгсэл дээр хувийн хамгаалалтын хөвөгч хэрэгсэл (аврах хантааз) -ийг заавал өмсөнө.			
Хувийн хамгаалалтын хөвөгч хэрэгсэл: IV загвар	Шаардлагагүй	Шаардлагагүй	✓
Галын хор, гал	✓	✓	✓

Бүртгэлийн дугаар 151
 БОНГОЛ УЛСЫН
 ЗАС, ТӨСВИЙН ЛАМ
 ХУВИЙН ҮЙСЭН
 14-06 сарын 09-ний өдөр

унтраагч В-1 төрөл			
Галын аюулыг зайлуулагч буцаах очлуур	✓	Их бие дотроо хөдөлгүүртэй, хойд удирдлагатай усан онгоц, завь, хэрэгсэлд шаардана	Их бие дотроо хөдөлгүүртэй, хойд удирдлагатай усан онгоц, завь, хэрэгсэлд шаардана
Агааржуулалтын систем	✓	✓	✓
Дуут дохио, шүгэл, хонх	Улсын чанартай, улсын хяналтад байгаа усанд үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд шаардана.	Улсын чанартай, улсын хяналтад байгаа усанд үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд шаардана.	✓
Аюул осолд орсныг илэрхийлэх өдрийн дохио тэмдгүүд	Шаардлагагүй	Шаардлагагүй	Улсын чанартай, улсын хяналтад байгаа усанд үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд шаардана
Аюул осолд орсныг илэрхийлэх шөнийн дохио тэмдгүүд	Улсын чанартай, улсын хяналтад байгаа усанд үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд шаардана	Улсын чанартай, улсын хяналтад байгаа усанд үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд шаардана	Улсын чанартай, улсын хяналтад байгаа усанд үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд шаардана
Усан онгоцны удирдлага, жолоодлогын гэрэл, дохионууд	✓	✓	✓

Бүртгэлийн дугаар ... 151 ...
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭГЭРЧИЙН ЯАМ
ХУУЛЬ ТЭГЭР ҮНЭН
Түүлбар олгогчийн амжилтын гарын үсэг
...
20 14 оны 06 сарын 09-ний өдөр